



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 4 дүгээр
сарын 30 өдөр

№ 1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 30 өдөр 17 цаг 00 минутад Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо “MN tower” 12 давхар 1204 тоот өрөөнд эхэллээ.

Д.Санжаа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа ирсэн та бүхэнд талархал илэрхийлэе. Хурал зохион байгуулах комиссын даргаар Д.Санжаа миний бие ажиллаж гишүүдээр нь Т.Ганчимэг, Г.Дуламдорж нар ажиллаж байна. Тооллогын комиссын даргаар Монсек ҮЦК-ийн захирал М.Отгонбаатар гишүүдээр нь Ш.Нарангарвуу, Ж.Батжил нар ажиллаж байна. ХЭХ-ыг журмын дагуу ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан удирдан зохион байгуулна.

М.Отгонбаатар: Хурлын ирц болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай тогтоолыг уншиж танилцуулав.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилэе. Тооллогын комиссын тогтоол гарлаа. Хурлын ирц 51 хувьдаа хүрсэн учир хурлыг нээсэнийг мэдэгдэе.

ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан: Хувьцаа эзэмшигчдийн хуралд сууж байгаа хувьцаа эзэмшигчид маань хурлынхаа дэгийн дагуу байна гэж найдаж байна. Гүйцэтгэх захиралын ажлын тайлан тавигдаад ирэх үед ТУЗ үнэлэлт өгч дараа жилд хөдөлмөрийн гэрээг сунгах талаар хэлэлцдэг байгаа. Тиймээс ТУЗ 2021 оны Д.Санжаа захиралын үйл ажиллагаанд хангалттай гэдэг дүгнэлт өгсөн байгаа. Гэхдээ хангалттай гэдэг нь сайн гэдэг үнэлгээ өгөөгүй нь 2021-2022 оны хоорондох хоёр гүйцэтгэх захиралын хоорондын бүрэн эрхийг дамнасан үйл ажиллагаа байсан. Д.Санжаа захирал нь 11 сараас гүйцэтгэх захиралын ажлыг хүлээж аваад 12 сард улсын бүртгэлд албажуулсан байгаа. Д.Санжаа захирал ажлын тайлангаа одоо тавина.

Д.Санжаа: Эрхэм хувьцаа эзэмшигч, ТУЗ-ын дарга, гишүүдээ Та бүхэнд энэ өдрийн энд хүргэе.

Өнгөрсөн 2021 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн танилцуулж байна. Тайлангийн хугацаанд “Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК”-ний төлөвлөж байсан томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж үргэлжлүүлэн ажиллаж байна.

Тэр дундаа “Хувьцаат орон сууц”, “Бизнес оновчлол” “Иргэний газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах” төслүүдийг үргэлжлүүлэн тодорхой шатанд хүргээд байна.

Хийж хэрэгжүүлсэн ажлаа уламжлал ёсоороо дараах 3 чиглэлд багцлан та бүхэнд хүргэе.

1. Дотоод ажлын талаар
2. Төсөл хөтөлбөрүүдийн явцын талаар



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

3. Цаашдын зорилтын талаар гэсэн 3 бүлэгт хуваалаа

НЭГ: ДОТООД АЖЛЫН ТАЛААР

Өнгөрсөн хугацаанд миний бие 2021 оны 12 дугаар сарын дундуур амаргүй сорилт, давааг туулж ирлээ. 2021 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит 1, ээлжит бус хурлыг 1, ТУЗ-ын хурлыг 13 удаа тус тус хуралдуулж тодорхой бүлэг асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хууль журмаар зохицуулагддаг харилцааг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж хууль зүйн тал дээр Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй Барисстер кастос фирм, Санхүү аудит тал дээр Релайнс аудит, үнэлгээний тал дээр Золач ХХК, цаашдын бизнес хөгжлийн тал дээр Тэргэл менежмент, хувьцаа бонд хөрөнгийн зах зээлийн тал дээр Монсек ҮЦК, маркетинг, сурталчилгааны Infinity marketing ХХК-уудтай тус тус хамтран ажиллах гэрээ байгуулан холбогдох ажилуудыг чиглэл чиглэлийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Хувьцаат орон сууц төсөл ТУЗ-аас батлагдсан дүрэм журмын хүрээнд ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийг MNS ISO 15489 стандартад оруулж архивд хадгалуулах журмыг биелүүлэн мөн компанийн бренд бүүкийг боловсруулж оюуны өмчийн газар бүртгүүлэхээр ажиллаж байна.

Хууль, журмаар зохицуулагддаг тайлан баланс гаргах, мэдээ мэдээлэл хүргэх ажлууд зөрчилгүй явж байна. Бид 2021 оны санхүүгийн тайланг санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй аудитын компани болох “Релайнс аудит ХХК”-р хөндлөнгийн хяналт оруулахад олон улсын стандартад нийцсэн бүртгэл хийгдэж байна зөрчилгүй гэж хэд хэдэн зөвлөмжтэй дүгнэлт гарсан.

Түүнийг гадна компанийн давуу эрхийг хувьцаа гаргах асуудал та бидний гаргасан шийдвэрүүдийг тусгай зөвшөөрөлтэй хуулийн фирм “Барисстер кастос ХХК” хянан монгол улсын хууль, дүрэм, журамд нийцэж байна гэсэн дүгнэлт өгсөн.

Үнэлгээний “Золач ХХК”-аар компанид төвлөрсөн нийт хөрөнгийг зах зээлийн ханшаар үнэлүүлж улсын бүртгэлд бүртгэлжүүлээд байна.

Бизнес маркетинг, ПР н хувьд салбартаа мэргэжлийнд тооцогддог infinity marketing ХХК-р ребрендинг хамтран хийхээр тохиролцож одоогийн байдлаар компанийн website, Брендбүүк, олон нийтийн сүлжээ буюу facebook хуудсыг тогтмол хөгжүүлж тодорхой өсөлт, хандалтууд аваад байна.



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Бизнес хөгжил, төлөвлөгөөний хувьд улсдаа олон жилийн туршлагатай, дээгүүрт тооцогддог “Тэргэл менежмент ХХК”-р Хувьцаат орон сууц төслийн ирээдүйн бизнес хөгжлийн төлөвлөгөө болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын суурь баримт бичгүүдийг олон улсын стандарт, монгол улсын хууль дүрэм журмын дагуу болгон засан шинэчилж байна.

Компанийн дотоод бүтцийг өөрчилж 4 хэлтэс 20 ажилтны бүтцийг бий болгоод байгаа хэдий ч одоогийн байдлаар

- Гүйцэтгэх захирал
- Ерөнхий нягтлан
- Тооцооны нягтлан
- Олон нийттэй харилцах менежер 2
- Хувьцаа, арилжааны мэргэжилтэн 1

нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

ХОЁР: ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЯВЦЫН ТАЛААР:

Өнгөрөгч 2020 оны 8-р сард эхлүүлсэн “ХУВЬЦААТ ОРОН СУУЦ” төслийн үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн Та бүхэнд танилцуулья.

Тодорхой хэдэн шалтгааны улмаас тус төсөл харилцагчид төсөлдөө итгэл алдрах байдал ажиглагдсан хэдий ч шуурхай хариу арга хэмжээ авч төслийн багш нартай 7 хоног болгон бүлэг хэсгээр нь биечлэн уулзалт хийж мэдээллүүдийг өгснөөр буцаалтыг өндөр түвшинд саарууллаа. Гэсэн хэдий ч өнөөдрийн байдлаар 10 хүний 1 нь эргэлзсэн 1 нь буцахаар шийдсэн байдалтай байгаа нь бидэнд ирж байгаа өргөдөл гомдолд хийсэн дүн шинжилгээгээр харж болох юм.

Өнөөдрийн байдлаар нийт 1387 хүн хувьцаат орон сууц төсөлд хамрагдсан хэвээр байгаа хэдий ч үүнээс 285 нь сар бүрийн төлөлтөө цаг тухайд нь хийхгүй зөрчилтэй байна.

“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ ТӨСЛИЙН ЖУРАМ”-ын хүрээнд зохион байгуулагдан явагдаж байна.

Журам батлагдсантай холбогдуулан компанийн гүйцэтгэх захирал, ажлын албанд өгөгдсөн үүрэг даалгаварын дагуу төсөл хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, эхлэлийн гүйцэтгэлүүдийг үе шаттайгаар төлөвлөх, төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг эзэнжүүлэх, цаг хугацааг тодотгох зэрэг ажлуудыг төлөвлөн гаргалаа.



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Ажлын төлөвлөгөөнд Төсөлд хэрэглэгдэх мөнгө санхүүгийн боломжуудыг нэгтгэн гаргах, хөрөнгө татан төвлөрүүлэх цаг хугацааг үе шаттай төлөвлөх, төсөлд оролцох хүн хүчний байршил, тоо хэмжээг тодотгох, холбоо тогтоон танилцуулга, тайлбар хийх, Улаанбаатар хотын хэмжээнд хэрэгжиж байгаа орон сууцны судалгаануудыг нэгтгэн гаргах, барилга угсралтын компаниудтай харилцаа тогтоох, хамтран ажиллах санал солилцох зэрэгт голлон төлөвлөгдөн явагдсан билээ.

Мөн төслийн журмын хүрээнд түүнд хэрэглэгдэх хэд хэдэн төрлийн бичиг баримтуудыг шинэчлэн боловсруулах шаардлага гарч бэлтгэл ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Төслийн журмын хүрээнд холбогдох дэд журмуудыг боловсруулан гаргах
- Төслийн бэлтгэл үе шатны гэрээг ахин шинэчлэх
- Төсөлд хамрагдсан харилцагчдийн гэрээг Худалдах худалдан авах, санхүүгийн түрээсийн болон түрээслээд өмчлөх зэргээр салган ангилах.
- Бидний харилцагч нартай хийгдсэн гэрээ үнэт цаасны тухай хуулиар үүсмэл үнэт цаас болж төвлөрсөн хадгаламжийн төв эсхүл кастадион банк дээр хадгалагдах тул хамтрагч хуулийн байгууллагын бэлтгэж өгсөн опцион болон фючерсийн гэрээг нийт харилцагч нартайгаа байгуулах.
- Хамтран ажиллах байгууллага, хамт олонтой хийх гэрээг боловсруулах
- Орон сууц захиалах хуудсыг боловсруулах
- Төсөлд оролцогчдийн хувийн мэдээллүүдийн хуудас бэлтгэх
- Дараа дараагийн төслүүдийн судалгаа шинжилгээний мэдээллийг цуглуулах
- Хувьцаажуулах бодлогын бичиг баримтыг боловсруулах, дарааллыг тогтоох

Зэрэг ажлууд шат дараатай хийгдсэн байна.

Бидний цаашдын үйл ажиллагаа өдөр ирэх тусам өргөжин тэлж байгаа болхоор хүрээгээ тэлж одоо байгаа компанийн оффиссдоо харилцагч, олон нийттэй харилцах хэлтэсээ үлдээж өөр арай хямд үнэтэй боломжийн газар бусад хэлтэсүүдээ нүүлгэх төлөвлөгөөтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дараагаас төсөл хөтөлбөрүүдийг эхлүүлэх, хамтрагч байгууллагуудтай удаа дараагийн уулзалтуудыг идэвхтэй явуулсны үндсэн дээр өнөөдрийн байдлаар 8 бүлэг байгууллага, 4 барилга угсралтын байгууллагуудтай хамтын ажиллагааны болон ажил үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна.

Бидний хамгийн анхлан хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажилласан хамт олон бол МОНГОЛЫН БАГШ НАРЫН ШИНЭ ЗУУН ЗӨВЛӨЛДӨХ ЗӨВЛӨЛ НҮТББ юм.



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Тус байгууллага нь Монголын багш нарын 7-р их хурлаас байгуулагдсан, боловсролын салбарын багш ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий байгууллага бөгөөд байгуулагдсан цагаасаа эхлэн багш нарын нийгмийн асуудлууд тэр дундаа багш нарыг орон сууцжуулах асуудлыг анхаарлынхаа төвд байлгаж, төр засгийн шат шатны үүрэг чиглэл бүхий байгууллагууд, хувийн хэвшлийн бүхий л байгууллагуудтай дээрхи асуудлаар ярилцаж, судалгаа шинжилгээ хийсэн, боломж гарцуудыг эрэлхийлсэн ажил хэрэгч байгууллага байлаа.

Хэд хэдэн удаагийн ажил хэрэгч уулзалтын дүнд бид хамтран ажиллаж санамж бичиг байгуулан “ХУВЬЦААТ ОРОН СУУЦ” төслийг хамтран хэрэгжүүлэхээр эрх хэмжээ, үүрэг хариуцлагаа тодорхойлон ажлаа эхлүүлцгээсэн г та бүхэн мэдэх билээ.

2020 оны 8-р сарын эхээр эхлүүлсэн бидний ажил өнөөдөр 1300 гаран багш, боловсролын салбарын ажилтныг хамран өргөжсөн бөгөөд улмаар салбарлан эмч эмнэлгийн ажилтан, урлаг соёлын ажилтан, цагдаа, цэрэг, онцгой алба хаагчдийнүүрэг чиглэл бүхий ТББ-ууд, зарим залуучуудийн хөгжлийн салбарыг хамран өргөжөөд байна.

Мөн төслийг дэмжиж Эмч эмнэлгийн байгууллагын салбарыг төлөөлөн “МОНГОЛЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЦЭГЦ ТАНХИМ” ТББ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд цаашдын хамтын ажиллагаагаа тохиролцон ажиллаж байна. Хамтрагч маань 3000 эмч эмнэлгийн ажилтныг төсөлд хамруулахаар төлөвлөсөнг та бүхэн мэдэх бизээ.

Монголын урлаг соёлын байгууллагын ажилтан ажилчид, байгууллагууд төсөлд хамрагдах саналаа ирүүлсний зэрэгцээ “Зохиогчийн эрхийг хамгаалах Болор төв” ТББ, “Монголын залуу цэргийн алба хаагчдийн нэгдсэн холбоо” ТББ бидэнтэй хамтран ажиллах хүсэлтээ удаа дараа илэрхийлж бид батлан хамгаалах сургуульд хэд хэдэн удаагийн ажил хэрэгч уулзалт хийлээ.

Төсөлд олон чиглэлийн үүрэг гүйцэтгэж байгаа Байгууллага хамт олон нэгдсэн бөгөөд Гэрлийн өргөө нэгдэл гишүүдийн хамт төслийн үйл ажиллагаанд оролцож байгаа билээ.

Өнөөдрийн байдлаар Хувьцаат орон сууц төсөлд нийт 1300 гаруй хувьцаа эзэмшигч оролцож байгаагийн дотор эхний 106 хувьцаа эзэмшигч орон сууцандаа ороод тав тухтай амьдарч байна.

Хувьцаат орон сууц төслийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байгаа хамт олон бол манай барилга угсралтын компаниуд байлаа.

Энэ ондоо бид 200-500 өрхийг орон сууцанд оруулах төлөвлөгөөтэй байна. Цаашид бидний төслийн гол мөн чанарыг ойлгож хамтран ажиллах санал солилцож буй олон байгууллага байна.



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Компани хөрөнгө татан төвлөрүүлэх, нэмэлт хөрөнгө босгох ажилдаа орж Хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүд, баг хамт олонтой хамтран компанийн “НОГООН БОНД” гаргах ажлыг 3 үе шаттай төлөвлөн судалгаа тооцооллын дагуу эхний ээлжинд 3 тэрбум 500 сая төгрөгийн үнэ бүхий 3500 ширхэг бондыг хаалттай гаргасан г та бүхэн мэдэх байх. Цаашид бид биржийн бус бирж буюу ОТС дээр гаргах ажлуудыг бэлтгэн явуулж байна. Цаашид бидэнтэй хамтран ажиллах сонирхолтой хэд хэдэн андерайтеруудаас сонгож ажиллана.

Өнөөдрийн байдлаар бид 800 орчим хувьцаа эзэмшигчтэй өнөр айл болоод байна. Энэ хагас жилээр бидний төлөвлөсөн нэмэлт хувьцааг зал зээлд гаргах үед 1500 орчим хувьцаа эзэмшигчтэй болох төлөвлөгөөтэй байна. Төсөлд Үндсэн хувьцаа эзэмшигчид идэвхитэй оролцож байгаад баяртай байна.

Өнгөрсөн хугацааны төслийн харилцагчдийн хувьцааны данс Монсек ҮЦК-д саадгүй нээгдэж нэмэлт хувьцаа гаргах үед саадгүй бичигдэх болсон мөн баяртай байн.

Төслийг хөдөө орон нутагт түгээн хэрэгжүүлэх бэлтгэл хийгдэж Багануур дүүрэг, Архангай аймаг, Булган аймаг, Хэнтий аймгуудад шинэ харилцагч нараа бүртгэж эхлээд байгаа билээ.

Хамтран ажиллаж байгаа багш нарын байгууллагын удирдлагууд салбарын сайд, холбогдох яам, агентлагт төслийн тухай өргөн дэлгэр мэдээллийг хүргэж, тодорхой хэмжээний дэмжлэг авч өөрсдийн ажлын хажуугаар энэ олон багш нартайгаа уулзаж төслийн үйл явц, нүр их тус болж байгааг хэлэхэд чин сэтгэлээсээ талархалтай байна.

ГУРАВ: ЦААШДЫН ЗОРИЛТ:

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ, ТУЗ-ийн дарга, гишүүд ээ.

Та бидний зорилт, зорилго өнөөдөр тун тодорхой байна. Хувьцаа эзэмшигчдийнхээ дунд зохион байгуулж байгаа төсөл арга хэмжээнүүдийн онцлогоос хамаарч Бид хамтдаа он удаан жил хамтран ажиллаж, амьдрах нөхцөл шаардлага бий болж байна.

- Эхлүүлсэн төслүүдээ амжилттай хэрэгжүүлэн тогтворжуулах
- Бидэнд итгэж компанийн том төслүүдэд хөрөнгө оруулалт хийж, итгэл сэтгэлээ өгсөн багш, эмч, хувьцаа эзэмшигчдээ орон сууцжуулах ажлыг хэрэгжүүлж дуусгах
- Салбар болгоны Ногоон Отог төлөвлөлтүүдийг эхлүүлэх



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

- Нэмэлт санхүүжүүлэлт, хөрөнгө татан төвлөрүүлэх ажлуудаа мэргэжлийн түвшинд удирдан зохион байгуулах
- Төслийн дараагийн үе шатуудыг эхлүүлэх, хэрэгжүүлэх

Төслийг хөдөө орон нутагт эрчимтэй үргэлжлүүлэх зорилт зорилгуудыг урдаа тавин ажиллаж байна. Баярлалаа

Ж.Жаргалсайхан: За тэгээд нэгдүгээр тогтоол болох компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслийг танилцуулав. Батлах уу ?

Хувьцаа эзэмшигчид: Батлая

Ж.Жаргалсайхан: Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг зөвшөөрөх тухай тогтоолын төслийг уншиж танилцуулав. Батлах уу?

Хувьцаа эзэмшигчид: Батлая

Ж.Жаргалсайхан: Гуравдах асуудал ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх тухай. Энэ дээр бол ТУЗ-ийн гишүүн Л.Ариунаа нь өөрийн санлаар чөлөөлөгдөх хүсэлтэй байгаа гэдгээ бичгээр ирүүлсэн байгаа. Тэрээр Монгол банкны хяналтын зөвлөлд байдаг учраас ажил нь амжихгүй гэж гарч байгааг дахин хэлэе. Харин нэр бүхий этгээдүүд нь зөрчил гаргасан талаар Аудитын хорооны гишүүн Д.Санжаа нь Аудитын хорооны дүгнэлтийг уншиж танилцуулна.

Д.Санжаа: ТУЗ-ын гишүүн Н.Алтансүх, И.Цог-эрдэнэ нар нь компанийн дүрмийн 7.27.1, 7.27.2, 7.27.4, 7.27.5-д заасан үүргийг тус тус зөрчсөн буюу 2021 онд “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн Аудитын дүгнэлтээр Н.Алтансүх нь 816,913,165 сая төгрөгийг хувьдаа ашигласан, компанийн мөнгийг зориулалтын бус ашигласан, “Хувьцаат орон сууц” төслийг санаатайгаар удаашруулсан, Н.Алтансүх, Цог-эрдэнэ нар нь “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-д ажиллаж байх хугацаандаа “Монгол ард түмнээ хөгжүүлэх сан” байгуулж улмаар “Түмт орон сууц 1” төслийг хамтран байгуулж “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн багш нарыг өөрсдийн байгуулсан шинэ компанитайгаа гэрээ хийхийгш уриалсан /“Түмт орон сууц 1” төслийн хамтын ажиллагааны гэрээгээр/ зэрэг ноцтой зөрчил гаргасан нь нотлох баримтаар тогтоогдож байна гэж үзэж байна.

ТУЗ-ын гишүүн Болор нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд суудаггүй, идэвхгүй гишүүн болох нь хурлын ирцээр тогтоогдсон. ТУЗ-ын хурлын ирцийг танилцуулах.

ТУЗ-ын гишүүн Л.Энхтуяа, Т.Пүрэвсүрэн нарын хувьд компанийн дүрмийн 7.27.1, компанийн төслийн нэрийг барин бусдаас авлига авч дараалал зөрчин бусдыг хохироосон, ёс зүйн зөрчил зэрэг ноцтой зөрчил гаргасан нь нотлох баримтаар тогтоогдож байна гэж үзэж байна

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-д ажиллаж байсан нягтлан бодогч Ч.Чинбат, менежер Отгонжаргал нар нь тус бүр 2 өрөө байрыг байгууллагын мөнгөөр авсан болох нь 2021 онд “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн хийсэн Аудитын дүгнэлтээр тогтоогдож байна.



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Ж.Жаргалсайхан: Тус хүмүүсийг ТУЗ-өөс чөлөөлөх хэрэгтэй гэж миний хувьд үзэж байна. Гээд гурав болон дөрөвдүгээр тоот тогтоолын төслийг уншиж танилцуулав. Батлах уу?

Хувьцаа эзэмшигчид: Батлая

Ж.Жаргалсайхан: За энэхүү хурлаар ТУЗ-ийн 6 гишүүнийг албан үүргээс нь чөлөөллөө. Одоо бид нэмж 6 гишүүн сонгох хэрэгтэй гээд ТУЗ-д нэр дэвших хүмүүсийг танилцуулна уу гэж Гүйцэтгэх захирал Д.Санжаад үүрэг болгов.

Д.Санжаа:

1. Б.Тулга-Зэвсэгт хүчний төлөөлөл
2. Ц.Баярмагнай-Зэвсэгт хүчний төлөөлөл
3. У.Мөнхбат Зэвсэгт хүчний төлөөлөл
4. Н.Оюунбилэг-Багш нарын зөвлөлийн төлөөлөл
5. Ш.Дүүриймаа-Багш нарын зөвлөлийн төлөөлөл
6. У.Энхтөр-Хууль хүчний байгууллагын төлөөлөл
7. Б.Энхмаа-Сэтгүүлч нарын төлөөлөл
8. С.Болорбайгаль-Урлаг, Соёлын төлөөлөл
9. Д.Отгонцэцэг Хувьцаа эзэмшигч нар энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшиж байна. Та бүхэн өөрсдийгөө товчхон танилцуулна уу.

Нэр дэвшигч Б.Тулга: та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би залуу цэргийн холбооны гишүүн Балданхүү овогтой Тулга гэж хүн байна. Армид 14 жил ажиллаж байна. Одоо жанжин штабд ажиллаж байгаа.

Нэр дэвшигч С.Болорбайгаль: Сайн байна уу, Намайг Болорбайгаль гэдэг би урлаг соёлоос залуу уран бүтээлчдийгээ энэхүү гайхалтай тогтолцоонд оруулан хамруулах хүсэлтэй орж ирж байгаа.

Нэр дэвшигч Б.Энхмаа: Сайн байна уу, Намайг Энхмаа гэдэг би сэтгүүлчдийн холбоонд найман жил ажиллаж байгаад одоо онцгой байдлын ерөнхий газар тав дах жилдээ ажиллаж байна.

Нэр дэвшигч У.Мөнхбат: Сайн байна уу, Намайг Уламбаярын Мөнхбат гэдэг зэвсэгт хүчинд 15 дах жилдээ ажиллаж байна. Одоогоор үндэсний батлан хамгаалах сургуульд багшилдаг, цөмийн зэвсэг хими, биологийн зэвсгийн мэргэжилтэн.

Нэр дэвшигч Ц.Баярмагнай: Сайн байна уу, Намайг Баярмагнай гэдэг би зэвсэгт хүчинд үүрэг гүйцэтгэж байгаа энэ төсөлд ихэд сонирхож байгаа баярлалаа.

Нэр дэвшигч У.Энхтөр: Сайн байна уу, Намайг Энхтөр гэдэг Цагдаагийн байгуулалт 18 жил ажилсаж байна, цагдаа нарыг энэ төсөлд хамруулах ихээхэн сонирхолтой байгаа.



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Нэр дэвшигч Д.Отгонцэцэг: Би бизнесийн байгууллагт 20 гаруй жил ажиллаж байгаа үндсэн хувьцаа эзэмшигч гэж ойлгож болно. Намайг Отгонцэцэг гэдэг Эдийн засагч мэргэжилтэй.

Нэр дэвшигч Н.Оюунбилэг: Бүгдээрээ сайн байна уу, би нийслэлийн 53-р сургуульд сургалтын менежер хийдэг. Дүүриймаа багштай хамт нэр дэвшиж байгаа. Багш нарынхаа дуу хоолойг хүргэж ажиллана. Баярлалаа.

Ж.Жаргалсайхан: Өнөөдөр бид сонгууль хийх хэмжээнд хүрнэ гэдэг болтолоо босоод байна. Тооллогоын комисс санал хураалтаа аваад дүнг нь танилцуулаарай. За дүн гартал асуулт, санал хүсэлтийг авъя

ХЭ-1: За ТУЗ-д хууль хүчний байгууллагаас орж байгааг нь дэмжиж байна. Өмнөх удирдлагын хийсэн алдааг давтахгүй бас хараа хяналт орж ирнэ гэдэгт итгэж байна.

ХЭ-2: Одоо энэ хувьцаат орон сууцны дараалал мэдээллийг нээлттэй шилэн болгох хэрэгтэй байна. Тэгэхгүй бол хэн хүн эрх мэдэлтэй нь урд хойгуур нь хүн оруулаад байх юм

Д.Санжаа: За манай компанийн веб сайт маань шилэн болж байгаа, дахин тийм асуудлыг гаргахгүй байхаар хичээж ажиллаж байна.

М.Отгонбаатар: За санал хураалтын дүнг гаргалаа. Эчнээгээр санлаа өгсөн болон танхимын ирцээс авсан санал хураалтын дүнг танилцуулая гээд ТУЗ-ийн нөхөн сонгуулийн дүнг танилцуулав.

Ж.Жаргалсайхан: За тэгвэл 5 болон 6 дугаар тоот тогтоолыг уншиж танилцуулаад, батлах уу?

Хувьцаа эзэмшигчид: Батлая

Ж.Жаргалсайхан: Үүгээр манай хэлэлцэх асуудал дуусаж байна. 2022 оны 4 дүгээр сарын 30 өдрийн ХЭХ өндөрлөсөнийг үүгээр мэдэгдэе.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

Д.САНЖАА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж.ЖАРГАЛСАЙХАН

